

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2018 оны 02 дугаар
сарын 14-ны өдөр

Дугаар А-25

Улаанбаатар
хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 26 дугаар зүйл, “Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан буюу хүндэт тэмдгийн тухай”, “Яам агентлагаас олгох шагналын тухай” Засгийн газрын 1997 оны 52, 53 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын шагнал “Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрийн тэргүүний ажилтан”, “Худалдаа, үйлдвэрийн тэргүүний ажилтан”, “Тэргүүний хоршоологч” хүндэт тэмдэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны “Жуух бичиг”-ээр шагнах журмыг 1 дүгээр хавсралтаар, “Шагналд нэр дэвшигчийн танилцуулга” –ын маягтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Салбарын тэргүүний ажилтан хүндэт тэмдэг, үнэмлэх, хавтас, яамны “Жуух бичиг” болон хавтас хийлгэхэд шаардагдах зардлыг жил бүр яамны төсөвт тусгаж байхыг Санхүүгийн хэлтэс /Б.Цогбадрах/-т даалгасугай.

3. Уг журмыг мөрдөж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Энхбат/-т үүрэг болгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан “Шагналын журам батлах” Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2015 оны 12 дугаар сарын 11–ны өдрийн А/152 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Б.БАТЗОРИГ

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2018
оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А-25 дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ШАГНАЛ
“ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРИЙН ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН” ХҮНДЭТ
ТЭМДЭГ, “ХУДАЛДАА, ҮЙЛДВЭРИЙН ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН” ХҮНДЭТ
ТЭМДЭГ, “ТЭРГҮҮНИЙ ХОРШООЛОГЧ” ХҮНДЭТ ТЭМДЭГ, ХҮНС, ХӨДӨӨ АЖ
АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ “ЖУУХ БИЧИГ”-ЭЭР ШАГНАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарыг хөгжүүлэхэд олон жил үр бүтээлтэй ажиллаж, бодитой хувь нэмэр оруулсан болон тухайн салбарт онцгой амжилт бүтээл гаргасан салбарын ажилтан, албан хаагч, иргэн мөн гадаад улсын иргэнийг Засгийн газрын болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны шагналаар /цаашид “шагнал” гэх/ шагнах, үрэгдүүлсэн гэмтээсэн тохиолдолд тэмдэг, үнэмлэхийг нөхөн сольж олгох, шагналын сан бүрдүүлэхэд энэхүү журмыг мөрдөнө.

Хоёр. Шагналын төрөл

2.1. Шагнал нь Засгийн газрын 1997 оны 52, 53 дугаар тогтоолд заасны дагуу дор дурдсан төрөлтэй байна.

2.1.1. Засгийн газрын шагнал:

- “Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрийн тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг
- “Худалдаа, үйлдвэрийн тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг
- “Тэргүүний хоршоологч” хүндэт тэмдэг

2.1.2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны шагнал:

- “Жуух бичиг”

Гурав. Шагнал олгох болзол

3.1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, жижиг, дунд үйлдвэр, хоршоо, худалдаа, нийтийн хоол, үйлчилгээний салбарыг хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан, өндөр үр ашигтай дэвшилтэт шинэ техник, технологи нэвтрүүлсэн, импорт орлох бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэн тодорхой үр дүнд хүрсэн, үйлдвэрлэл, хөдөлмөрийн зохион байгуулалтыг боловсронгуй болгож, хэрэглэгчдийн эрх ашигт нийцсэн чанартай, найдвартай үйл ажиллагааг хэрэгжүүлсэн, ажлын шинэ арга барил туршлагыг нэвтрүүлж эзэмшсэн, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд тодорхой хувь нэмэр оруулсан тухайн салбарт 15-аас доошгүй жил ажилласан ажилтан, албан хаагч болон иргэдийг “Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрийн тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг, “Худалдаа, үйлдвэрийн тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг, “Тэргүүний хоршоологч” хүндэт тэмдгээр, 10-аас доошгүй жил ажилласан аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан, албан хаагч болон иргэдийг Яамны “Жуух бичиг”-ээр тус тус шагнаана.

3.2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд биечлэн оролцож, үр ашигтай хамтын ажиллагааг бэхжүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулсан гадаадын иргэнийг шагнаж болно.

3.3. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт “Онцгой” гавьяа байгуулсан ажилтан, албан хаагч, иргэнийг “Салбарын тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг, эсвэл яамны “Жуух бичиг”-ээр ажилласан хугацааг харгалзахгүйгээр шагнана.

3.4. Шагналыг шат дараалан олгох бөгөөд өмнө нь шагнагдсан шагналаас хойш 5-ааш доошгүй жил тогтвортой ажиллаж, ажлын амжилт, үр бүтээл нь өмнөх түвшингээс ахисан нөхцөлд дараагийн шатны шагналд нэр дэвшүүлж тодорхойлно.

Дөрөв. Шагналд нэр дэвшүүлэх, тодорхойлох

4.1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, жижиг, дунд үйлдвэр, хоршоо, худалдаа, нийтийн хоол, үйлчилгээний салбарын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж байгаа ажилтан, албан хаагч болон тухайн байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад ажилтан, уг салбарт хамаарагдах төрийн албан хаагчийг үндсэн байгууллага нь шагналд тодорхойлно.

4.2. Аль нэг байгууллага, аж ахуйн нэгжид харьяалагддаггүй ахмадууд болон хувийн аж ахуй эрхэлдэг иргэдийг оршин сууж буй баг, хороо, сум, дүүргийн Засаг дарга тодорхойлж болно.

4.3. Шагналд нэр дэвшүүлэх ажилтан, албан хаагчыг аж ахуйн нэгж, байгууллагын хамт олны /томоохон үйлдвэр, аж ахуйн газрын хувьд цех тасгийн ажилчдын/ хурлаар, 4.2-т заасан иргэдийг баг, хорооны иргэдийн нийтийн хурлаар хэлэлцэж хурлын тэмдэглэлийг баталгаажуулсан байна.

4.4. Шагналд нэр дэвшсэн хүний ажил байдлын тодорхойлолт нь нийт ажилласан хугацааны ажлын амжилт, үр бүтээл, салбарт оруулсан хувь нэмэр, шагнуулах үндэслэлийг тодорхой бичиж, ажлын үзүүлэлт, нээлт бүтээлийн жагсаалтыг хавсаргаж, байгууллагын дарга гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулсан байна.

4.5. Шагнуулах хүний тодорхойлолтод нутгийн захиргааны байгууллага /аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, дүүргийн Засаг даргын тамгын газар/-ын саналыг авна.

4.6. Шагналд нэр дэвшүүлж тодорхойлохдоо дор дурдсан баримт бичгийг бүрдүүлнэ:

4.6.1. Шагнуулах тухай хүсэлт гаргасан аж ахуйн нэгж, байгууллагын албан бичиг;

4.6.2. Шагналд нэр дэвшигчийн танилцуулга /2 дугаар хавсралтаар батлагдсан загварын дагуу/;

4.6.3. Ажил байдлын тодорхойлолт

4.6.4. Хамт олны хурлаар хэлэлцсэн тухай албан тэмдэглэл;

4.6.5. Яамны “Жуух бичиг”-ээр шагнагдсан бол түүний хуулбар;

4.6.6. Онцгой амжилт гаргасан бол түүнийг гэрчлэх баримт бичиг, шийдвэрийн хуулбар;

4.6.7. Нутгийн захиргааны байгууллагын санал /4.5 -д заасан/;

4.7. Төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллага, бусад олон нийтийн байгууллагаас хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын аль нэг байгууллагад ажилладаг албан хаагчийг шагнуулах санал дэвшүүлсэн тохиолдолд тухайн хүний ажиллаж байгаа байгууллагаас заавал санал авсан байна.

4.9. Шагналд тодорхойлсон баримт бичгийг 30-аас доошгүй хоногийн өмнө цаасан хэлбэрээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд ирүүлнэ.

4.8. Шагналтай холбоотой баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн нь нотлогдсон тохиолдолд тухайн ажилтан, албан хаагч, иргэнийг дараагийн 5 жилд аливаа нэг шагналд нэр дэвшүүлсэн тодорхойлолтыг шийдвэрлэхгүй.

Тав. Шагналыг шийдвэрлэх, олгох

5.1. Шагналыг дараах нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан олгоно.

5.1. Үндэсний их баяр наадам;

5.2. Цагаан сар;

5.3. Шинэ жил;

5.4. Их Эзэн Чингис хааны өдөр;

5.5. Шинэ ургацын өдрүүд;

5.6. Салбарын ажилтан, ажилчдын өдрүүд;

5.8. “Салбарын тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг, яамны “Жуух бичиг”-ийг байгууллагын ой болон хүмүүсийн насны ойг тохиолдуулан олгохгүй.

5.9. “Салбарын тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг, яамны “Жуух бичиг”-ээр шагнуулахаар ирүүлсэн баримт бичгийг яамны Бичиг хэргийн эрхлэгч хүлээн авч бүртгэн, Сайд, Төрийн нарийн бичгийн дарга болон Төрийн захиргааны удирдлагын газрын даргад танилцуулж, шагналын асуудал хариуцсан мэргэжилтэнд өгнө.

5.10. Төрийн захиргааны удирдлагын газрын шагналын асуудал хариуцсан мэргэжилтэн шагналд тодорхойлсон баримт бичгийг хүлээн авч энэхүү журамд заасан болзол, баримт бичгийн бүрдэл хангасан ажилтан, албан хаагч, иргэдийг шагнах тухай шийдвэрийн төсөл боловсруулж, холбогдох газруудад танилцуулан санал авах ба Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд тушаал гаргана.

5.11. Хувийн дугаар бүхий “Салбарын тэргүүний ажилтан” үнэмлэх болон яамны “Жуух бичиг” дээр зөвхөн Засгийн газрын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд гарын үсэг зурж баталгаажуулна.

5.12. Шагналыг тодорхойлсон аж ахуйн нэгж, байгууллага болон аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, дүүргийн Засаг даргын тамгын газрын эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэн өгнө.

5.13. “Салбарын тэргүүний ажилтан” хүндэт тэмдгийн дагалдах мөнгөн шагнал 100.000 / Нэг зуун мянган/ төгрөг, яамны “Жуух бичиг”-ийн дагалдах мөнгөн шагнал

50.000 /Тавин мянган/ төгрөг байна. Энэхүү дагалдах мөнгөн шагналыг тухай хүнийг шагнуулахаар тодорхойлсон байгууллага олгоно. Гадаадын иргэнд дагалдах мөнгөн шагнал олгогдохгүй.

5.14. Шагналд тодорхойлсон ажилтан албан хаагч, иргэн нь 3.1-д заасан болзол хангаагүй, баримт бичгийг 4.6-д заасны дагуу бүрдүүлээгүй тохиолдолд шагнал олгохгүй.

5.15. Шагнагдсан болоод шагнагдаагүй хүмүүсийн баримт бичгийг буцаан олгохгүй бөгөөд архивын нэгж болгон хадгална.

Зургаа. Хүндэт тэмдэг, үнэмлэх нөхөн болон сольж олгох

6.1. “Салбарын тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг, үнэмлэх болон яамны “Хүндэт жуух бичиг”-ийг үрэгдүүлсэн буюу гэмтээсэн тохиолдолд нөхөн болон сольж олгож болох ба дараах баримт бичгийг бүрдүүлэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн захиргааны удирдлагын газарт хандана:

6.1.1. Тэмдэг, үнэмлэх нөхөн олгохыг хүссэн өргөдөл;

6.1.2. Иргэний үнэмлэхийн хуулбар;

6.1.3. Шагналын үнэмлэхийн хуулбар;

6.1.4. Үнэмлэхээ үрэгдүүлсэн бол шагнасан шийдвэрийн хуулбар;

6.1.5. Мөнгө тушаасан баримт;

6.2. Шагналын асуудал хариуцсан мэргэжилтэн өргөдлийг хянан үзээд хүндэт тэмдэг, үнэмлэх, “Жуух бичиг”-ийг нөхөн болон сольж олгох үндэслэлтэй гэж үзвэл “Салбарын тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг, үнэмлэх нөхөн олгоход 20000 /хорин мянга/ төгрөг, “Жуух бичиг” нөхөн олгоход 10000 /арван мянга/ төгрөгийн төлбөрийг холбогдох байгууллага, иргэнээс гаргуулсны дараа олгоно.

6.3. Хүндэт тэмдэг, үнэмлэх нөхөн олгох төлбөрийг яамны дансанд төвлөрүүлж, шагналын сан бүрдүүлнэ.

6.4. Шагналын санд төвлөрсөн мөнгийг “Салбарын тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг, үнэмлэх, “Жуух бичиг”, тэдгээрийн хавтас хийлгэх зардалд зарцуулна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2018
оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А-25 дугаар
тушаалын 2 дугаар хавсралт

“ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРИЙН ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН” ХҮНДЭТ
ТЭМДЭГ, “ХУДАЛДАА, ҮЙЛДВЭРИЙН ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН” ХҮНДЭТ
ТЭМДЭГ, “ТЭРГҮҮНИЙ ХОРШООЛОГЧ” ХҮНДЭТ ТЭМДЭГ ЯАМНЫ “ЖУУХ
БИЧИГ”-ЭЭР ШАГНУУЛАХААР НЭР ДЭВШҮҮЛСЭН ХҮНИЙ ТАНИЛЦУУЛГА

1. Ургийн овог:

2. Эцэг/эхийн нэр

3. Нэр:

4. Төрсөн он:

5. Хүйс:

6. Регистрийн дугаар:

7. Төрсөн аймаг, сум, хот:

8. Одоогийн харъяалал:

9. Боловсрол:

10. Ажилладаг салбар:

11. Мэргэжил:

12. Урьд болон одоо эрхэлж байгаа ажил /хүснэгтэд бичнэ/:

№	Ажлын газрын нэр	Хугацаа	Эрхэлсэн ажил
1.			

13. Улсад ажилласан жил:

14. Үүнээс: Тухайн салбарт ажилласан жил:

15. Урьд нь шагнагдаж байсан шагналууд: /Монгол Улсын цол, одон медаль, яамны “Жуух бичиг” болон бусад/

№	Шагналын нэр	Хэдэн онд
1.		

16. Шагнуулах үндэслэл:

17. Ямар шагналаар шагнуулах хамт олны санал:

18. Хамт олны саналын хувь:

БАЙГУУЛЛАГЫН ДАРГА БОЛОН
ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ГАРЫН ҮСЭГ,
ТАМГА /ТЭМДЭГ/

Зураг